

АЖЛЫН БАЙРНЫ ЗАР

Байршил: Налайх дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс

Эхлэх хугацаа: 2025/11/10

Дуусах хугацаа: 2025/11/24

Ажил эхлэх хугацаа: 2025/11

Цалин: Боловсрол, ажлын туршлагыг харгалзана.

Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр 2013 онд байгуулагдсан Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль (МГТИС) нь Монгол Улсын төрийн өмчит дээд боловсролын байгууллага юм. Тус сургууль нь Монгол Улсын болон ХБНГУ-ын Засгийн газрын дэмжлэгтэйгээр үйл ажиллагаагаа явуулдаг.

РЕКТОРЫН ТУСЛАХ

Гүйцэтгэх үндсэн чиг үүрэг:

- Ректорын өдөр тутмын ажлын хуваарийг зохицуулах, уулзалт, арга хэмжээг төлөвлөх, бэлтгэл ажлыг хангах, хурал уулзалтын тэмдэглэл хөтлөх;
- Ректорын тушаал, албан бичгийг албажуулах, хөтлөх, архивлах, хэрэгжилтэд хяналт тавих;
- Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлангийн мэдээллийг нэгтгэж, холбогдох байгууллагад хүргүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- Төрийн болон байгууллагын цахим системд холбогдох мэдээлэл, өгөгдлийг хугацаанд нь оруулж, тайлагнах.

Тавигдах шаардлага:

- Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх;
- Монгол хэлний найруулга зүйн, албан бичиг боловсруулах ур чадвартай байх;
- Зохион байгуулах, харилцааны өндөр ур чадвартай байх;
- Хариуцлагатай, зарчимч, ёс зүйн хэм хэмжээг баримтлан ажилладаг байх;
- Англи хэлний аман болон бичгийн дундаас дээш түвшний мэдлэгтэй байх;
- Компьютерын өргөн хэрэглээний программуудыг эзэмшсэн байх;
- Захиргааны чиглэлээр 2-оос доошгүй жил эсвэл дээд боловсролын байгууллагад ажиллаж байсан бол давуу тал болно.

Бүрдүүлэх материал:

- Ажилд орох өргөдөл
- Товч намтар - CV
- Мэргэжлийн ур чадварыг тодорхойлсон диплом, сертификат болон батламжийн хуулбар
- Өмнөх ажил олгогчийн тодорхойлох захиа – 2 хувь

Холбоо барих:

Та баримт бичгээ англи, монгол хэл дээр бэлтгэн 1 PDF файл болгон эмхэтгэж recruitment@gmit.edu.mn хаягаар бидэнд ирүүлнэ үү.

Цахим хуудас: www.gmit.edu.mn

Утас: +976 7023-2090

Жич: Зөвхөн шаардлага хангасан ажил горилогчидтой эргэн холбогдож ажлын ярилцлагад урих болно.